

МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

<http://www.frc.gov.mn>




***ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ,  
ХЯНАЛТ ТҮҮНИЙ ЧИГ ХАНДЛАГА***

**ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР**

*Улаанбаатар хот  
2014.11.20*


# АГУУЛГА



- Үнэт цаасны салбарын зохицуулалтын орчин;*
- Өнөөгийн байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;*
- Зохицуулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй гадаад хамтын ажиллагаа*
- Салбарын цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ;*

# НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

*Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд*



# НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

## ХУУЛЬ ТОГТООМЖ:



- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль /2005/
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2013/
- Компанийн тухай хууль /2011/
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль /2013/
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль /2010/
- Банкны тухай хууль /2010/
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль /2011/
- Бусад дүрэм, журам, арга, аргачлал

# НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

- **Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013)**
  - зохицуулалтын олон улсын стандарт
  - мэдээллийг ил тод, нээлттэй болгох харилцаа
  - хариуцлага
  - санхүүгийн хэрэгсэл /хөрвөх үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, хадгаламжийн бичиг/
  - номинал эзэмшигч, бенефициар өмчлөгчийн, кастодианы үйлчилгээ;
  - давхар бүртгэл, хадгаламжийн бичиг
  - зохицуулалтын арга хэлбэрүүд
  
- **Компанийн тухай хууль (2011)**
  - компанийн засаглалын гол зарчмууд
  - нээлттэй тайлагналын тогтолцоо
  - жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг
  - ногдол ашгийн бодлого
  - ТУЗ-ийн зохистой удирдлага, хяналтын бүтэц



# НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН



## ■ Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль (2013)

- хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа
- хөрөнгө оруулалтын сангийн төрөл, хэлбэр, нэгж эрхийн зохицуулалт, хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулж болох актив хөрөнгийн төрөл
- санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа, тайлагнал
- Хөрөнгө оруулалтын сангийн удирдлага

## ■ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010)

- хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төрөл, хэлбэр
- энэ төрлийн үнэт цаасыг гаргах харилцаанд оролцогч этгээд /ТЗК, ОССК, анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч гэх мэт/
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны суурь хөрөнгө, түүний төрөл
- Нягтлан бодох бүртгэл, аудит, хөндлөнгийн хяналтын бүтэц

# НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

## Шинээр батлагдсан журмууд:

- Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам
- Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам
- Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, бүртгүүлэх харилцааг зохицуулсан
- Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам
- Зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн журам
- Хадгаламжийн бичиг гаргах, бүртгэх харилцааг зохицуулсан журам
- Үнэт цаасны бүртгэл, давхар бүртгэлийн харилцааг зохицуулсан журам



## НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

### Шинээр батлагдсан журмууд:

- Зохицуулалттай этгээдийн эрсдлийн сангийн журам
- Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх журам
- Кастодианы үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн журам
- Хаалттай хувьцаат компанийн тухай журам
- Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах харилцааг зохицуулсан журам
- Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээллийн харилцааг зохицуулсан журам,
- Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах /market manipulation/-ыг хориглох үйл ажиллагааны журам
- Хөдөө аж ахуйн бирж арилжааны үйл ажиллагаатай холбоотой багц журам /4 журам/



## ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын байгууллагын 2 үндсэн хэлбэр байна.

- Дагнасан /АНУ – SEC, Hong Kong –SFC, Malaysia-SEC../
- Төвлөрсөн нэг байгууллага /Япон – FSA, Солонгос – FSC, FSS, Англи – FSA/
- Хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах
  - ХК-ийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлт
  - ХК-д газар дээрх хяналт шалгалт
  - Хөрөнгө оруулагч үнэт цаасны арилжаанд оролцоход брокер нь хууль, журмын дагуу үйлчилж байгаа эсэх
- Зах зээлийн шударга тогтолцоо хангах /market integrity/
  - Дотоод мэдээлэл ашиглалт /insider dealing/
  - Зах зээлийг урвуулан ашигласан эсэх /market manipulation/



# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Хувьцаат компани 304

Хөрөнгө оруулалтын  
мененжмент 2

Брокер, дилер 66

Зохицуулагч  
байгууллага 1

Андеррайтер 27  
Кастодиан банк 2

Хөрөнгийн зах  
зээлийн оролцогчид

Мэргэжлийн холбоо 1

Хөрөнгө оруулалтын  
зөвлөх 15

Төлбөр тооцоо,  
хадгаламжийн  
байгууллага 1


Төлбөр тооцоо  
гүйцэтгэх 4 арилжааны  
банк

Үнэт цаасны арилжаа  
эрхлэгч 1

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Хөрөнгө оруулагч, харилцагчдийн арилжаанд эзлэх хувь /2014 III/

■ Гадаадын ААН ■ Гадаадын иргэн ■ Дотоодын ААН ■ Дотоодын иргэн




□ Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойших 2014 оны 3 дугаар улирлын байдлаар төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 783,534 холболтын 133,044 данс нээгдсэн байна. Үүнээс:

- дотоодын иргэний 779,187
- гадаадын иргэний 1,760,
- дотоодын аж ахуйн нэгжийн 2,414,
- гадаадын аж ахуйн нэгжийн 173 данс үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй байна.

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

- Зах зээлийн үнэлгээ ба ТОП 20 индекс



ЗЗҮ болон Топ-20 индексийн үзүүлэлт 2005-2010 онуудад тогтмол өсөх хандлага ажиглагдсан ба 2011 онд огцом өссөн хэдий ч эргээд макро эдийн засгийн нөхцөл, байдлаас шалтгаалан 2013-2014 онуудад буурах хандлагатай байна.

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ


## ДНБ-д зах зээлийн үнэлгээг харьцуулсан хувь



2014 оны 3 дугаар улирлын ЗЗҮ-ийг мөн улирлын үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ний дүнд харьцуулахад 9.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны жилийн эцсийн дүнгээс даруй 0.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Үнэт цаасны арилжаа /2014.11.04/



- 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийг хүртлэх байдлаар өссөн дүнгээр нийт 215 удаагийн арилжаагаар 41.6 сая ширхэг хувьцааг 17.6 тэрбум төгрөгөөр арилжисан байна.
- 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 04-ний өдрийн хооронд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжаагаар Засгийн газрын 45.0 мянган ширхэг өрийн хэрэгслийг 4.3 тэрбум төгрөгөөр арилжисан байна.

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ


## Ногдол ашиг тараалт




2014 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 27 хувьцаат компани 52.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг тараалтын дүнг өмнөх оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 40.81 тэрбум төгрөгөөр буюу 3 дахин өссөн дүнтэй байна.

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөг)



ХАА биржээр арилжигдсан түүхий эдийн хэмжээ төрлөөр (хувиар)




2014 оны 3 дугаар улирлын байдлаар Хөдөө аж ахуйн биржээр 527.7 тэрбум төгрөгийн түүхий эд арилжигдсан нь 2013 оны дүнгээс 30 хувиар буюу 124.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.



# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт




- Санхүүгийн тайлангаа олон нийтэд мэдээлсэн компанийн тоо
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулсан компанийн тоо
- "МХБ" ХК-д хувьцаа нь арилжигдаж, үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа компанийн тоо

- 2010 онд Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдснаас хойших хугацаанд хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт эрс сайжирсан төлөв ажиглагдаж байна.
- Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны мэдээллийн нэгдсэн сангийн журам”-аар хувьцаат компаниудад хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийн байдал МХБ-ээр дамжуулан арилжаалагддаг, аж ахуйн үйл ажиллагаа нь явагдаж буй 185 ХК-ийн хувьд дээрх судалгаа дараах байдалтай байна.

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны мэдээлэл (2014.09.30)



# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

## Зайны хяналт

### Зохицуулалттай этгээд

- Нийт 68 зохицуулалттай этгээдэд 2013 оны санхүүгийн тайлангийн хариу, мэдэгдлийг хүргүүлэв.
- Үнэт цаасны зах зээлийн тойм, хөгжлийн статистик үзүүлэлтүүдийг улирал, хагас жил, жилээр гаргаж нийтэд хүргэж байна.
- Зохицуулалттай этгээдийн мэдээллийн санг шинэчилж, тэдгээрийн улирал бүрийн санхүүгийн үйл ажиллагааны тайланг цахим хэлбэрээр FinA системд хүлээн авах ажилбарыг тогтмолжуулж нийтэд хүргэх
- Боловсон хүчний мэдээллийг нэгтгэж хяналт тавих
- Тохиромжтой этгээдийг тодорхойлох

### Хувьцаат компани

- Хувьцаат компаниудад хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах ажиллагааны талаарх мэдээлэл хүргүүлж хурлын зохион байгуулалтад хяналт тавьж ажилладаг;
- Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх үүрэгтэй баримт материалын цаг тухайд ирүүлж байгаад хяналт тавих, холбогдох анхааруулга хүргүүлэх;
- Хувьцаат компаниудын ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг сонгохдоо Компанийн тухай хуульд заасныг баримтлан шийдвэрлэх анхааруулга;
- Хувьцаат компаниуд өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгийн зохистой харьцаа болон ногдол ашиг хуваарилах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх талаар зөвлөмж.
- Монголбанктай хамтарч хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүйгээс ТУЗ, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх нь дуусгавар болсон нийт 130 ХК-ийн талаарх мэдээллийг нийтэд хүргэж, холбогдох төрийн байгууллага болон банкуудад энэ талаар мэдээллийг хүргэх.

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

## Зайны хяналт

### Хөдөө аж ахуйн брокерийн компани

- Нийт 34 ХААБ-ын 2013 оны санхүүгийн тайлангийн хариу, мэдэгдлийг хүргүүлэв.
- Хөдөө аж ахуйн биржийн зах зээлийн тойм, хөгжлийн статистик үзүүлэлтүүдийг улирал бүрээр гаргаж байна
- ХААБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд хяналт тавьж ажиллаж байна.

### Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны оролцогч ТЗК, ОССК

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч ТЗК-ийн санхүүгийн тайланг улирал бүр авч хяналт тавьж байна.
- Хөрөнгийн багцын бүртгэл хөтлөгч, үйлчилгээ үзүүлэгч, анхны үүрэг гүйцэтгэгчээс мэдээлэл гаргуулж ажиллаж байна
- Үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт үнэт цаасны хадгаламжийн байгууллагад хэрхэн явагдаж байгаа талаар улирал бүр мэдээлэл авч хяналт тавьж байна.
- ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаа тогтмол явагдаж байгаа эсэх
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээнд хяналт тавих

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

## Газар дээрх хяналт

### Зохицуулалттай ЭТГЭЭД

- Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрөл эрхлэх эрх бүхий 2014 онд 24 компайн үндсэн үйл ажиллагаанд шалгалт хийсэн
- Мөн онд 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй 31 брокер дилерийн компанийн салбарын үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалт хийв.

### Хувьцаат компани

- 4 чиглэлд нийт төлөвлөгөөт 24 ХК
- Төлөвлөгөөт бус 1 ХК

### ХААБ, ОССК болон ТЗК

- ХААБ-ийн 10 компани
- 2 ТЗК-ийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн
- 1 ОССК-ийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн.

# ХОЁР. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

- Хувьцаат компаниудын удирдлагад Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар нийт 11 удаагийн сургалт зохион байгуулсан.

Хүн ам их төвлөрсөн хөдөө орон нутгийн хувьцаат компаниудын удирдлага, хувьцаа эзэмшигчид, орон нутгийн захиргаа болон төрийн эрх бүхий байгууллагын албан тушаалтнуудад дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хувьцаат компанитай холбоотой эдийн засгийн болон эрх зүйн харилцааны шинэ зохицуулалтын талаар сурталчилгаа хийсэн.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 7 удаагийн нэвтрүүлэгт оролцож үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчны шинэчлэлийн талаарх ярилцлага өгсөн.

Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж, 91 хүнд гэрчилгээ олгосон.



# ХОЁР. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

## Зохицуулалттай байгууллагуудад зориулсан сургалт семинар:

- “Үнэт цаасны төлбөр, тооцооны системийн эрсдлийн удирдлага, олон улсын санхүүгийн зах зээл дахь кастодианы үйл ажиллагаа” сэдэвт Хонгконг, Солонгос, Япон, Их Британи зэрэг 4 орнуудын болон өөрийн орны мэргэжилтнүүдийг хамруулсан олон улсын семинар;
- Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагын удирдах ажилтнуудын хоёрдугаар зөвлөлгөөн;
- “Кастодианы үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн журмын төслийг боловсруулах” ажлын хэлэлцүүлгүүд;
- “Компанийн тухай хуулийн хэрэгжилт, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ ба компанийн засаглалын кодекс”-ийн өөрчлөлт сэдэвт арга хэмжээг тус тус зохион байгуулсан.



# Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр





# ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Санхүүгийн зохицуулах хороо нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-ын гишүүн бөгөөд 2014 оны 6 дугаар сард тус Хороо IOSCO-ийн олон талт хамтын ажиллагаанд нэгдэн орж, гарын үсэг зурсан. Ингэснээр тус Хороо IOSCO-ийн 200 орчим гишүүн орнуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах өргөн боломжтой болсон. Мөн түүнчлэн тус байгууллагын үнэт цаасны зах зээлийн талаар гаргасан зөвлөмж, сайн турлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээс гадна тодорхой чиглэлээр зах зээлийн оролцогчыг мэргэшүүлэх, сургах бэлтгэх боломжтой болж байгаа юм.



БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороотой хамтын ажиллагааны санамж бичгийг 2013 оны 1 дүгээр сард байгуулсан бөгөөд үүний дагуу хоёр байгууллага илэвхтэй хамтран ажиллаж байна. Үүний хүрээнд БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хорооны зохицуулалтын салбаруудад зохион байгуулагдаж буй сургалт, мэдээлэл солилцох ажиллагаанд хамтран ажиллаж байна.

## ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Хонгконгийн үнэт цаас, фьючерсийн хороотой үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах, зах зээлийн шударга, ил тод, үр ашигт байдлыг хангах хүрээнд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх Санамж бичигт 2013 оны 10 дугаар сард гарын үсэг зурсан.

Хонгконгийн болон Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын тайлан, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, ашиг сонирхлын тухай мэдээллийг нийтэд хүргэх ба зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагааг эхлүүлэх нь олон улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн нийтлэг стандартыг төлөвшүүлэх, мэдээллийн технологи болон хүний нөөцийн сургалт, дадлагажилт зэрэгт онцгой ач холбогдолтой. Санамж бичгийн хүрээнд мэдээлэл солилцож ажиллаж байна.



Японы Санхүүгийн үйлчилгээний агентлагтай хамтын ажиллагааны санамж бичгийг 2014 оны 5 дугаар сард 2 байгууллагын дарга байгуулсан бөгөөд үүний дагуу хоёр байгууллагын хамтран үйл ажиллагааг эхлүүлж тус Хорооны Үнэт цаасны газрын 2 албан хаагч Японы Санхүүгийн үйлчилгээний хороонд урт хугацааны дадлагажих хөтөлбөрт хамрагдаж байна.

Дээрх Санамж бичгийн ач холбогдол нь ажилтнууд тусгайлсан мэргэжлийн сургалтад хамрагдах, хөгжингүй орны зохицуулагч байгууллагатай урт хугацааны хамтын ажиллагааны эхлэлийг тавьсанд оршино.

## ДӨРӨВ: ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



- Санхүүгийн зах зээлийн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, УИХ-аар батлуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;
- Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, хөрөнгө оруулалтын сан байгуулах ажлуудыг идэвхжүүлэх, дэмжих;
- Томоохон чадавхи бүхий үндэсний компаниудыг хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргахыг дэмжиж, хамтран ажиллах дэд бүтцийг бий болгох;
- Үнэт цаасанд хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч болон нийтэд үнэт цаас гаргаж байгаа этгээдийн үйл ажиллагааг татварын хөнгөлөлтийн нөхцлөөр дамжуулан дэмжих;
- Зохицуулалттай этгээдэд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын зарчмыг хэрэгжүүлэх, хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоон мөрдүүлэх;
- Үнэт цаасны хороодын Олон Улсын Байгууллага / IOSCO/-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд бүхий талаар санаачлагатай ажиллах;

## ДӨРӨВ: ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



- Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн хувьцааны тодорхой хэсгийг, үе шаттайгаар хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах чиглэлээр ажиллах;
- Үнэт цаасны зах зээлийн гадаад, дотоод судалгаа, шинжилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд зах зээлд анхааруулга, зөвлөмж хүргүүлэх чиглэлээр ажиллах;
- Засгийн газар, орон нутгийн болон компанийн өрийн хэрэгслийг Хөрөнгийн биржээр арилжаалах хэмжээг хэмэгдүүлэх;
- Гадаадын үнэт цаасыг монголын үнэт цаасны зах зээлд арилжаалах нөхцлийг бүрдүүлэх;
- Зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцох үйлдэлд тавих хяналтыг эрчимжүүлж, ийм төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;



# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

Jambaajants\_t@frc.mn

